



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 02 өдөр

Дугаар A/90

Биндэр сум

**Өмч хамгаалах байнгын зөвлөл
шинэчлэн байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх заалт, Хэнтий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 11 дүгээр хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Биндэр сумын Засаг даргын Тамгын газрын Өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай. *

Зөвлөлийн дарга: Хөдөө аж ахуйн тасгийн дарга

Гишүүд: Онон багийн Засаг дарга

Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн

Нягтлан бодогч

Архив, бичиг хэргийн эрхлэгч

2.Холбогдох хууль, заавар журмын дагуу үр дүнтэй ажил зохион байгуулахыг өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн A/28 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН